



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



**ҮЛ ХӨДЛӨХ,
ЭД ХӨРӨНГИЙН
ЗЭЭЛ**

Зээлийн танилцуулга

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, оффис болон бусад бизнес эрхлэн явуулах зориулалттай бэлэн ашиглалтанд орсон барилга, барилгын тодорхой хэсэг талбай худалдан авах, бэлэн ашиглалтанд ороогүй барилгын гүйцэтгэлийг дуусгах, эсвэл шинээр барих, өргөтгөл хийх болон засварлахад зориулагдана.

Танд ямар боломж, давуу тал бий болох вэ?

- Хямд, урт хугацаатай эх үүсвэрээр өөрийн үндсэн хөрөнгөтэй болох боломж;
- Зээлийн урт хугацаа;
- Зээлээр санхүүжигдэж буй үл хөдлөх хөрөнгө өөрөө зээлийн барьцаа болно.

Зээлийн нөхцөл

Зээлийн хэмжээ	Худалдан авч буй хөрөнгийн үнэлгээний 70% хүртэл					
Зээлийн хугацаа	120 сар хүртэл			121-180 сар хүртэл		
Зээлийн хүү	20.4%	19.2%	18.0%	20.8%	19.6%	18.4%
Урьдчилгаа төлбөр	20%-30%	31%-40%	41%-с дээш	20%-30%	31%-40%	41%-с дээш
Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	12 сар хүртэл					
Зээлийн шимтгэл	0.5%					
Даатгал	Зээлээр худалдан авсан, барьсан барилга, барилгын талбайг эд хөрөнгийн даатгалд даатгуулна.					

Бүрдүүлэх бичиг баримт

Хуулийн этгээдийн хувьд

- Зээлийн хүсэлт – Байгууллага (маягт 069), санхүүгийн баримтад гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн мэдээлэл (Маягт 070);
- Улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Компанийн дүрэм;
- Зээл авах, компанийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавихыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол (ТУЗ);
- Санхүүгийн тайлан (сүүлийн нэг жилийн);
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз;
- Бизнесийн үйл ажиллагааны товч танилцуулга (шаардлагатай тохиолдолд);
- Байгаль, орчин нийгмийн хариуцлагатай холбоотой баримт бичиг.
- Бусад бичиг баримт

Иргэний хувьд

- Зээлдэгч, хамтран зээлдэгч тус бүрийн Зээлийн хүсэлт – Иргэн (Маягт 068);
- Нотариатаар баталгаажуулсан иргэний үнэмлэхийн хуулбар (зээлийг хамтран хариуцах хүнд мөн адил хамаарна);
- Үйл ажиллагаа явуулах лиценз, зөвшөөрөл;
- Орлогын бүртгэлийн дэвтэр (хар дэвтэр), дансны хуулга, байгаа бол аж ахуйн нэгжийн сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан;
- Гэрлэлтийн гэрчилгээ (гэрлээгүй бол гэрлэсэн эсэх лавлагаа);
- Бусад бичиг баримт

Тавигдах шаардлага:

Иргэн бол эрхэлж буй бизнесийн чиглэлээр 1-ээс доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан туршлага, санхүүгийн чадвартай, үйл ажиллагааны орлого тогтвортой байх;

Хуулийн этгээд бол Байгууллагын хувьд 2 жилээс багагүй хугацаанд, Жижиг, дунд бизнес эрхлэгчийн хувьд 1 жилээс багагүй хугацаанд эрхэлж буй бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа тогтвортой эрхэлсэн туршлагатай, бизнесийн үйл ажиллагааны орлогоос зээлийн төлбөрийг бүрэн төлөх чадамжтай байх.

Зээлээр санхүүжүүлэх барилга нь доор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Бизнесийн зориулалттай байх;
- Үйлдвэр, үйлчилгээ ба оффисын барилга баригдах дэвсгэр газар нь зөвхөн тухайн зориулалтаар ашиглахаар холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авсан байх;
- Үл хөдлөх эд хөрөнгө нь холбогдох эрх бүхий байгууллагуудын зөвшөөрөл, гэрчилгээ, дүгнэлт, техникийн нөхцөл болон бусад стандартын шаардлагуудыг бүрэн хангасан байх;
- Дэд бүтцийн асуудал шийдэгдсэн байх буюу дулааны шугам сүлжээг татахтай холбоотойгоор нэмж гарч болзошгүй зардал болон эх үүсвэр нь тодорхой байх;
- Банкнаас тавигдах бусад шаардлагууд.



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1900-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn